

D- PARLIAMENT БАЙРШУУЛСАН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

№	Ирүүлсэн саналын агуулга	Санал ирүүлсэн этгээд	Тусгасан эсэх	Тайлбар
1.	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний талаар хуульд тусгах, бие даасан зүйл болгох тухай	Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, эмч нар	Туссан	Хуулийн төслийн 13 дугаар зүйлд “Уламжлалт анагаах тусламж, үйлчилгээг хүргэх зохицуулалт” туссан.
2.	“Эмнэл зүйн задлан шинжилгээ хийхтэй” холбоотой 2 зүйлийг хуулийн төслөөс хасах тухай	Эмч Баярмаа	Туссан	Хуулийн төслийн 57.2-д санал туссан.
3.	Хуулийн төслөөс “сум дундын эмнэлэг”-тэй холбоотой заалтыг хасах тухай	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Тусаагүй	Уг хуулийн төсөлд “сум дундын нэгдсэн эмнэлэг” гэсэн зохицуулалт байхгүй.
4.	Хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ одоогоор байхгүй тул хасах тухай	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Тусаагүй	Уг хуулийн төслөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх шатлалыг олон улсад байдаг жишгийн дагуу анхан, хоёрдогч, лавлагаа гэж ангилдаг дагуу ангилж зохицуулсан.
5.	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсгийн “Анхдагч шатлал”-ыг “Анхан шатны” болгон солих	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Тусгаагүй	Уг хуулийн төсөлд “анхдагч шатлал” гэсэн нэр томьёо байхгүй.
6.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “хорин дөрвөн цаг түүнээс дээш хугацаагаар” гэж тусгах	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	туссан	Хуулийн төслийн 3.1.23-д санал туссан.
7.	3.1.11-т заасныг “хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” гэж өвчин нь илаарьших боломжгүй болсон, өвчний сүүлийн шатандаа орсон өвчтөнд өвдөлтийн зовуурь шаналгаа, шаналгаатай	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Туссан	Хуулийн төслийн 3.1.21-д санал туссан.

	шинжийг багасгахад чиглэсэн эмчилгээ, сувилахуй, сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлж амьдралын чанарыг нь сайжруулах зорилготой нийгмийн болон халамжийн цогц тусламж үйлчилгээ” гэж өөрчлөх			
8.	Хуулийн төслийн 5.4-т заасныг “Өрхийн эрүүл мэндийн төв нь амбулаторийн тусламж, үйлчилгээг өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн болон, ерөнхий мэргэжлийн эмч дотор, эх хүүхэд, нярай, ахмад настан, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ зэргийг эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэх, хянах, сэргээн засах тусламж, үйлчилгээг өдрийн хэлбэрээр, сувилахуйн тусламж үйлчилгээг, гэрээр үзүүлэх анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэж өөрчлөх тухай	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Туссан	Хуулийн төслийн 6.2-д санал туссан.
9.	Хуулийн төслийн 6.13.1-т “Амбулаторийн тусламж, үйлчилгээг өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эсхүл ерөнхий мэргэжлээр үзүүлэх” гэж өөрчлөлт оруулах	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Туссан	Хуулийн төслийн 6.2-д санал туссан.
10.	Хуулийн төслийн 6.13.3-т “Шаардлагатай тохиолдолд хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлэгт шилжүүлэх, эргэх холбоо тогтоох, эргэн хянах” гэж зааснаас хоёрдогч гуравдагч шатлалыг хасах	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Тусаагүй	Хуулийн үзэл баримтлалтай нийцээгүй.
11.	17.5.1-т тухайн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний хүн амд хамаарах 60 хүртэлх насны иргэн байх; хамаарах	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Хэсэгчлэн туссан	Хуулийн төсөлд нас зааж хязгаарласан зохицуулалт байхгүй, бусад агуулгын тухайд

	насны хүрээг 60 гэж тогтоосноо эргэн харах тухай			хуулийн төслийн 16.5-д санал туссан.
12.	17.14.1-т заасныг “Хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн байх, эсхүл өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн бол давуу байх бөгөөд, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх” гэж өөрчлөх	АШУҮИС-ийн Өрхийн Анагаах Ухааны тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор профессор Д. Мягмарцэрэн	Тусаагүй	Агуулга хуулийн төсөлд байсан.
13.	Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийг зохицуулсан заалтууд нь хоорондоо утга нь давхацсан, засаглал, тогтолцооны ялгаа ойлгомжгүй, магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл байгуулах шаардлага байгаа эсэх тухай	“Чанарыг иргэн бүрийн эрүүл мэндэд” НҮТББ -ын сургалт хариуцсан менежер, АУ-ны доктор Б.Бурмаа	Хэсэгчлэн туссан	Хуулийн “Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл” зүйлд дээрх агуулгууд давхацсан байсан тул засварласан. Харин магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл нь олон улсад байдаг хараат бус бие даасан засаглалын хэлбэр тул хуульд туссан.
14.	Хуулийн төслийн 3.1.2-т заасныг “эмнэлгийн тусламж үйлчилгээ” гэж эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх өвчин, эмгэг, гэмтэл бэртэл, хордлого, биеийн үйл ажиллагаа, чадвар алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, хүндрэлээс сэргийлэх, сэргээн засах, хөнгөвчлөх, эрүүл мэндийн мэндийн боловсрол олгох цогц үйл ажиллагааг” гэж өөрчлөх тухай	АУ-ны доктор, профессор А.Балжинням	Туссан	Хуулийн төслийн 3.1.28-д санал туссан.
15.	3.1.14-т заасныг “Өвчин эмгэгийн дараах хяналт” гэж өвчтөн эмчилгээ, мэс засал, сэргээн засах зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээ авсны дараа эрүүл мэндийн байдал, үйл	АУ-ны доктор профессор А.Балжинням	Туссан	Хуулийн төслийн 3.1.8-д санал туссан.

	ажиллагааны чадварт нь хяналт тавих, өвчин эмгэг дахин сэдрэхээс сэргийлэх, хүндрэл, чадвар алдагдлаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд дахин үнэлгээ, эмчилгээ хийх зорилготой, эмч, эмнэлгийн мэргэжилтний үзлэг оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг” гэж өөрчлөх тухай			
16.	3.1.16-т заасныг “өвчтөн” гэж оношлуулах, эмчлүүлэх, урьдчилан сэргийлэх, сэргээн засах, хөнгөвчлөх зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа эсхүл авах шаардлага үүссэн хүнийг” гэж өөрчлөх тухай	АУ-ны доктор профессор А.Балжинням	Хэсэгчлэн туссан	Хуулийн төслийн 3.1.6-д туссан
17.	3.1.18 дэх заалтад тодорхойлсон “нөхөн сэргээх эмч” гэх нэршил нь буруу нэршил тул хасах; хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, туслах технологич зэрэг нь манай улсад бие даасан мэргэжилтнээр бэлтгэгдэж байгаа тул тус тус нэмэх	АУ-ны доктор профессор А.Балжинням	Туссан	Хуулийн төслөөс хассан.
18.	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2-т “нөхөн сэргээх” гэх нэршил буруу тул сэргээн засах болгож өөрчлөх тухай	АУ-ны доктор профессор А.Балжинням	Туссан	Хуулийн төсөлд нэршлийг засах санал туссан.
19.	Нэгдсэн эмнэлэг заавал сэргээн засахын тасагтай байх ёстой тус хуулийн төслийн 8.2-т “сэргээн засах” гэж нэмэх	АУ-ны доктор профессор А.Балжинням	Тусаагүй	Хуулийн төсөлд уг санал туссан байсан.
20.	Тус хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасныг “Сэргээн засах тусламж үйлчилгээ шаардлагатай, ямар нэг зорилгот үйл хийж чадахгүй, бэрхшээлтэй бүх насны, бүх төрлийн	АУ-ны доктор профессор А.Балжинням	Туссан	Хуулийн төслийн 14.1-д санал туссан.

	өвчин эмгэгийн үед бусад мэргэжлийн тусламж үйлчилгээтэй нэгэн зэрэг цогц эсвэл дагнасан байдлаар тасралтгүй хэлбэрээр үзүүлнэ” гэж өөрчлөх тухай			
21.	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан Сэргээн засах тусламж, үйлчилгээний төрлүүдийг хуульд дэлгэрэнгүй тусгах	АУ-ны доктор профессор А.Балжинням	Тусаагүй	Хуулийн төсөлд уг санал туссан байсан.
22.	Сэргээн засах төвийн сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэхдээ хэрэгжүүлэх чиг үүргийг тусгах тухай	АУ-ны доктор профессор А.Балжинням	Тусаагүй	Хуулийн төсөлд уг санал туссан байсан.
23.	Цахим түүхийн хадгалалтыг тодорхой заах	Иргэн Энхжаргал	Тусаагүй	Өвчний цахим түүхийн хадгалалттай холбоотой зохицуулалт нь өөр хуулиар зохицуулагддаг.
24.	4.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг дараах байгууллага үзүүлнэ: Орон нутгуудад үйл ажиллагаа явуулж байгаа УАУ-ны нэгдсэн эмнэлэг гэсэн тодотгол оруулах	Иргэн Мөнхбат	Тусаагүй	Хуулийн төсөлд Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг-ийн зохицуулалт орсон байгаа. Харин эрүүл мэндийн байгууллагыг газар зүйн байршлаар төрөлжүүлж хуульд зохицуулах нь нийтлэг зохицуулалтыг алдагдуулдаг.
25.	Сувилахуйн төв гэсэн нэр томъёоны тайлбар нэмэх	Иргэн Энхболд	Тусаагүй	Сувилахуйн төвийн зохицуулалт нь зөвхөн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд зохицуулагдах боломжгүй давхар Нийгмийн халамжийн хууль, санхүүжилтийг зохицуулах Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар цогц байдлаар зохицуулагдана.

26.	Нөхөрлөлтэй холбоотой заалтууд Нөхөрлөлийн тухай хуулийг зөрчиж байгаа тухай	Иргэн Жавзан-Орлом	Туссан	Хуулийн төсөлд Нөхөрлөлийн тухай хуультай холбоотой зохицуулалтыг хассан.
27.	47.2.4 Халдварын сэргийлэлт хяналт гэдэг нэр томьёо байхгүй. Англи хэлний Infection Prevention Control гэдэг нэр томьёо Халдварын сэргийлэлт хяналт гэж заншсан, одоогийн тушаалд хэвшээд явж байгаа	Иргэн Баттогтох	Туссан	Хуулийн төслийн 38.4.7, 45.1.5, 46.1.4-д санал туссан.
28.	56.4.1-д зааснаар задлан шинжилгээ хийх эсэхийг эмч биш эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дарга, түүнтэй дүйцэхүйц албан тушаалтны шийдвэрлэнэ гэж оруулах	Иргэн Саруул	Тусаагүй	Хуулийн төсөлд энэхүү харилцааг төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулахаар туссан байгаа.
29.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль зүйн техникийн хувьд сайжруулах тухай	Иргэн Б. Цогням	Туссан	Хуулийн төслийг D-Parliament -д байршуулах хугацаанд мэргэжлийн хуульчдын баг хууль зүйн техник тал дээр дахин ажиллаж холбогдох засварыг хийсэн.

Дүгнэлт: Хуулийн төсөлтэй холбоотой нийт 29 саналыг хувь, байгууллагаас ирүүлснээс 14 санал туссан, 3 санал хэсэгчлэн туссан, 12 санал тусаагүй.